

САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН МОДУЛЬ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Захиалагч: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Гүйцэтгэгч: Зөвлөх /2 хүн/

Хугацаа: 1 сар

Үндэслэл

Нэгдсэн үндэстний байгууллага нь “Сайн дурын ажил бол дэлхий даяар, бүх нийгэмд буй хүй хамтлаг (community)-ийн хүч чадвартай, бас энэрэнгүй байхын үндсэн эх сурвалж юм” гэж тодорхойлсон бөгөөд аливаа улс оронд зовлон бэрхшээл тулгарахад иргэд сайн дураараа нэгдэж, хүч хөрөнгө, мэдлэг чадвараа дайчлан хүчээ нэгтгэж чадвал тухайн бэрхшээл хүнд хэцүү нөхцөл байдлыг гарз, хохирол багатай даван туулдаг.

Нөгөө талаас, сайн дурын ажил нь хувь хүний төлөвшилд эерэгээр нөлөөлдөг бөгөөд төлөвшиж буй өсвөр үеийнхэн, залуучууд сайн дурын ажлын талаар мэдлэг, ойлголттой, оролцох идэвх сонирхолтой байснаар удирдах, зохион байгуулах, багаар ажиллах, бусадтай хамтрах, ойлголцох чадвар хөгжихийн зэрэгцээ бусдыг энэрэн туслах сэтгэлтэй болж төлөвшдөг.

Иймээс сайн дурын ажил нь нийгэм болон хувь хүнд олон талын өгөөжтэй арга хэмжээ юм.

Манай улсад сайн дурын ажлыг дэмжих, сайн дурын ажлын нийгмийн болон хувь хүний өгөөж, давуу талыг нэмэгдүүлэх, Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийг хэрэгжүүлэх хүрээнд “Сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/130 дугаар тушаалаар баталсан.

Энэхүү журмаар хараа хяналтгүй хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудыг нийгэмшүүлэх; ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамж, халамжийн байгууллагуудыг дэмжих; эрх ашиг зөрчигдсэн залуучууд, хүмүүсийн эрх ашгийг хамгаалах, эргэн нийгэмшихэд туслах; аливаа хүчирхийллийн хохирогч болсон хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучууд, иргэдэд туслах, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх; гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх; нийгмийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл зан үйл, дадал хэвшил төлөвшүүлэх; нийгмийн хэв журмыг сахиулах; замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах; гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх; орчны бохирдол, цаг уурын өөрчлөлт, агаарын бохирдлыг бууруулах зэрэг олон чиглэлээр залуучуудын сайн дурын ажлыг дэмжих, сайн дурын ажлын гүйцэтгэл, үр нөлөөг харгалзан ажлын туршлагад тооцох, мэдээллийн санд бүртгэн баталгаажуулах зэрэг харилцааг зохицуулсан.

Залуучуудын сайн дурын ажлыг дэмжиж “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам, загвар”-д нийтэд тустай сайн дурын, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд манлайлан оролцсон бол удирдан зохион байгуулах, багаар ажиллах чадварын үнэлгээнд давуу талд тооцохоор тусгаад байна.

Иймд сайн дурын ажил санаачлах, манлайлах, оролцох залуучуудын идэвх, сонирхол нэмэгдэхтэй холбогдуулан сайн дурын ажлыг удирдах, чиглүүлэх, зохион байгуулах хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, сургах, мэргэшүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Зорилго

Сайн дурын үйл ажиллагааг удирдах, чиглүүлэх, зохион байгуулах ур чадварыг олгох сайн дурын үйл ажиллагааны сургагч багш бэлтгэх сургалтын модуль хөтөлбөрийг боловсруулахад оршино.

Ажиллах хугацаа

Сургалтын модуль хөтөлбөрийг 2019 оны ... сарын ... өдрөөс ... сарын ... өдөр хүртэл 30 хоногийн хугацаанд боловсруулна.

Гүйцэтгэх ажлын хүрээ

Зөвлөхийн ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гэрээний хавсралтаар батлах бөгөөд дараахь ажлыг тусгана. Үүнд:

1. Сайн дурын ажлыг зохион байгуулж буй байгууллага, талуудын үйл ажиллагаатай танилцах, тулгамдсан, дутагдалтай асуудлыг тодорхойлох;
2. Сайн дурын үйл ажиллагааны сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулах;
3. Төслийг холбогдох талуудад танилцуулах, саналыг тусган сайжруулах;
4. Эцэслэсэн хөтөлбөрийг ХНХЯ-нд хүлээлгэн өгөх.

Хүлээлгэн өгөх бүтээгдэхүүн

Сайн дурын үйл ажиллагааны сургагч багш бэлтгэх сургалтын модуль хөтөлбөрийг эцэслэн захиалагчид хүлээлгэж өгнө.

Зөвлөхүүдэд тавигдах шаардлага

Зөвлөх үйлчилгээний агуулгатай нийцүүлэн дараахь чиглэлээр зөвлөхүүдийг сонгон шалгаруулж ажиллуулна. Үүнд:

1. сургалтын хөтөлбөр боловсруулах,
2. сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулах.

Зөвлөхүүдэд дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

1. Боловсрол:
 - 1.1 Хууль, эрх зүй, боловсрол, нийгмийн чиглэлээр магистр буюу түүнээс дээш зэрэгтэй;
 - 1.2 Сургалтын хөтөлбөр боловсруулах чиглэлээр мэргэшсэн;
 - 1.3 Сайн дурын үйл ажиллагаа төлөвлөх, удирдах, чиглүүлэх, зохион байгуулах чиглэлээр мэргэшсэн.
2. Туршлага:
 - 2.1 Бодлогын баримт бичиг, стандарт боловсруулах, батлуулах чиглэлээр ажлын туршлагатай;
 - 2.2 Төрийн бодлого, үйл ажиллагаа, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх чадвартай;
 - 2.3 Сургалтын хөтөлбөр боловсруулах, сайн дурын үйл ажиллагааг удирдах, чиглүүлэх, зохион байгуулах чиглэлээр ажиллаж байсан туршлагатай бол давуу талтай;
 - 2.4 Дээр дурдсан чиглэлээр 5 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх;
3. Хэлний ур чадвар:
 - 3.1 Англи хэлийг мэргэжлийн чиглэлээр хэрэглэх түвшинд эзэмшсэн байх;
4. Мэргэжлийн ур чадвар:
 - 4.1 Эрх зүйн баримт бичиг, MNS үндэсний стандарт боловсруулах;
 - 4.2 Баримт бичиг боловсруулахад шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ, тооцоог бие даан хийх, дүгнэлт гаргах;
 - 4.3 Баримт бичгийн төсөл хэлэлцүүлэхэд хамгаалах, батлуулахад нөлөөлөх;
 - 4.4 Уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, удирдан чиглүүлэх;
 - 4.5 Компьютерийн хэрэглээний програмуудыг чөлөөтэй ашиглах;
 - 4.6 Богино хугацаанд, хурдтай, бие даан ажиллах, хувийн зохион байгуулалт сайтай байх;
 - 4.7 Холбогдох салбарт ашиг сонирхлын зөрчилгүй байх.

Бүрдүүлэх материал:

1. Уг ажлыг хийх сонирхлыг илэрхийлсэн хүсэлт;
2. Товч намтар;
3. Мэргэжил, мэргэшил, мэдлэгийг нотлохуйц баримтууд, үүнд диплом, сертификат, гэрчилгээний хуулбар;
4. Ажил гүйцэтгэх төлөвлөгөө

Хяналт, тайлагналт

- Зөвлөх нь явцын/эцсийн тайлан, бүтээгдэхүүн хүлээлгэн өгөх хугацаа зэргийг тусгасан ажлын календарчилсан төлөвлөгөөг боловсруулж гэрээнд хавсаргана.

- ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газрын Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн удирдлага, холбогдох ажилтнуудтай байнга холбоотой ажиллана.
- ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газрын Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга, холбогдох ажилтнууд нь зөвлөхийн ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавина.

Хугацаа

- Зөвлөх үйлчилгээний гэрээг 30 хоногийн хугацаатай байгуулна.
- Захиалагчид эцсийн бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгсөн хэдий ч бүтээгдэхүүний хэрэглээ, сайжруулалттай холбоотой асуудлаар зөвлөхүүд захиалагчтай шаардлагатай үед хамтран ажиллана.

Санхүүжүүлэгч:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

- Зөвлөхийн гэрээний төлбөр 6.000.000 /зургаан сая/ төгрөг байна.
- Зөвлөхийн ажлын хүрээ, ажил үүргийн хуваарийг талууд тохиолцсоны үндсэн дээр гэрээний төлбөрийг 70/30 хуваарьтайгаар гэрээг байгуулна.
- Гэрээний төлбөрийн нийт дүнд хувь хүний орлогын албан татвар /гэрээний төлбөрийн 10 хувь/ багтсан болно.
- Захиалагчид эцсийн бүтээгдэхүүнийг бүрэн хүлээлгэн өгсний дараа гэрээний үлдэгдэл төлбөр болох 30 хувийг олгоно.

-oOo-